

“АМЖИЛТЫН ГАРАА - 4” ШАЛГАЛТЫН ЗӨВЛӨМЖ

(АНГЛИ ХЭЛ)

Англи хэлний хичээлээр нийслэлийн 9 дүүргийн нийт 3730 суралцагчид хамрагдаж, гүйцэтгэлийн хувь 41,4% байна. Үүнд: 90-100 хувийн гүйцэтгэлтэй 61 сурагч /1.6%, 80-89 хувийн гүйцэтгэлтэй 131 сурагч /3,5%, 70-79 хувийн гүйцэтгэлтэй 214 сурагч /5,7%, 60-69 хувийн гүйцэтгэлтэй 266 сурагч /7,1%, 0-59 хувийн гүйцэтгэлтэй 3058 сурагч /81,9%/ дүгнэгдсэн байна.

Шалгалтын бүтэц: Англи хэлний шалгалтын сэдэв нийт 60 даалгавартай. Үүнээс харгалзуулах 4 даалгавартай. Даалгаврын хувилбар бүр адил бүтэцтэй. Үүнд:

- I. Дүрмийн 3 хэсэг даалгавартай. 1-р хэсэг нь дүрмийн хувьд сонгох 5 даалгавар, тус бүр 1 оноотой. Энэ хэсэг нь дүрмийн хувьд мэдээллийг төрөлжүүлэх, ангилах, жагсаах чадварыг шалгасан. 2-р хэсэг нь дүрмийн хувьд алдааг олох 5 даалгавар, тус бүр 2 оноотой. Энэ хэсэг нь шаардлагатай мэдээллийг таньж илрүүлэх чадварыг шалгасан. 3-р хэсэг нь дүрмийн хувьд хэлц үйл үгийн хэрэглээг шалгасан 5 даалгавар, тус бүр нь 2 оноотой. Нийт дүрмийн хэсэг нь 25 оноотой.
- II. Үгийн сангийн 3 хэсэг даалгавартай. 1-р хэсэг нь үгийн мэдлэгийн хүрээг шалгасан даалгавар 5, тус бүр 1 оноотой. 2-р хэсэг нь үгийн хэлбэрийн зөвийг өгүүлбэрт тааруулан сонгох 5 даалгавар, тус бүр 2 оноотой. 3-р хэсэг нь угтвар үгтэй хэллэгүүдийг тухайн үгтэй тааруулан сонгох 5 даалгавар, тус бүр 2 оноотой. Нийт үгийн сангийн хэсэг нь 25 оноотой. Дээрх даалгаврууд үгийн нөөц хэл зүйн мэдлэгийг зөв хэрэглэх чадварыг шалгасан. Мөн үг, холбоо үг, өгүүлбэрийг зөв холбох чадварыг шалгасан.
- III. Харилцан ярианы 2 хэсэг даалгавартай. 1-р хэсэг нь харгалзан тааруулах даалгавар 4, тус бүр 1 оноотой. 2-р хэсэг нь харилцан ярианы зөв хариултыг олох 6 даалгавар, тус бүр 1 оноотой. Нийт харилцан ярианы хэсэг нь 10 оноотой. Энэ хэсэг нь шаардлагатай мэдээллийг таньж илрүүлэх чадварыг шалгасан. Харилцан ярианы сэдвүүдийг голдуу амьдралд өргөн хэрэглэгдэх тохиолдлууд, сургууль, сургуулийн орчинд яригдаж болох сэдвүүдийг сонгосон.
- IV. Унших 2 хэсэг даалгавартай, эхэд гарсан шинэ үг хэллэгийг ойлгох, хэрэглэх чадварыг тандсан даалгавруудыг оруулж өгсөн.
- V. 1-р хэсэг нь даалгаврын хувьд арай хөнгөн мэдээлэл тодорхойлох даалгавар 10, тус бүр 2 оноотой. 2-р хэсэг нь шинжлэн судлан дүгнэх даалгавар 10, тус бүр нь 2 оноотой. Нийт унших хэсэг 40 оноотой.

Даалгаврууд нь хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон, танин мэдэхүйн сонирхолтой сэдвүүд сонгосон бөгөөд Олон улсын жишигт тохируулан түүх, шинжлэх ухаан, газар зүй зэрэг чиглэлүүдээр бэлтгэсэн эхүүдийг оруулж өгсөн. Асуулт тус бүр нь Блүүмийн таксономи дээр тулгуурласан учраас хөнгөнөөс гүнзгийрсэн, тодорхой үе шатуудыг хамарсан. Хоёр дахь даалгаврын хувьд арай илүү академик үг хэллэг орсон, хүүхдийн ойлгох, сэтгэх, дүгнэлт хийх чадварыг шалгасан даалгаварууд байсан.

Сурагчдын гүйцэтгэлийг үнэлгээний 8 түвшингээр харуулбал:

Хүснэгт 1.

түвшин	Гүйцэтгэлийн хувь	Нийт гүйцэтгэсэн сурагчдын тоо
VIII	90-100	61
VII	80-89	131
VI	70-79	214
V	60-69	266
IV	50-59	389
III	40-49	569
II	30-39	1019
I	0-29	1081

Хүснэгт 1-ээс харахад шалгуулагчдаас:

VIII түвшинд 90 -100% -ийн гүйцэтгэлтэй 61 суралцагч буюу 1,63 хувь,

VII түвшинд 80- 89% -ийн гүйцэтгэлтэй 131 суралцагч буюу 3,51 хувь,

VI түвшинд 70-79% -ийн гүйцэтгэлтэй 214 суралцагч буюу 5,73 хувь,

V түвшинд 60-69% -ийн гүйцэтгэлтэй 266 суралцагч буюу 7,13 хувь,

IV түвшинд 50-59% -ийн гүйцэтгэлтэй 389 суралцагч буюу 10,4 хувь,

III түвшинд 40-49%-ийн гүйцэтгэлтэй 569 суралцагч буюу 15,3 хувь,

II түвшинд 30-39%-ийн гүйцэтгэлтэй 1019 суралцагч буюу 27,3%,

I түвшинд 1081 суралцагч буюу 29 хувь байна.

Даалгаврын гүйцэтгэлийг сонгосон сурагчдын тоо, үнэлгээгээр харуулбал:

График 1.




График 1-ээс харахад хувилбаруудын хэлбэлзэлийн харьцаа дараах байдалтай байна.

А дүнтэй 13-17, хэлбэлзэлийн харьцаа 4

В дүнтэй 19-47, хэлбэлзэлийн харьцаа 28

С дүнтэй 38-65, хэлбэлзэлийн харьцаа 27

D дүнтэй 61-72, хэлбэлзэлийн харьцаа 11

F дүнтэй 726-770 хэлбэлзэлийн харьцаа 44

С хувилбарын даалгавруудыг гүйцэтгэж буй сурагчдын тоо их, харин А хувилбарын даалгавруудыг гүйцэтгэсэн сурагчдын тоо бусдаасаа цөөн байна.

Хүснэгт 2.

Даалгаврыг гүйцэтгэсэн байдлаар харуулбал:

№	A	B	C	D	дундаж
1. Grammar	40.18	42.24	34.34	35.46	38,05
2. Error	46.24	39.5	38.50	45.3	42,4
3. Phrasal	40.24	28.12	30.45	30.18	32,2
дундаж	42,22	36,62	34,43	36,98	37,6
4. Vocabulary	33.96	43.12	36.76	42.22	39,01
5. Word formation	47.1	53.62	35.78	28.68	41,2
6. Prepositions	35.68	33.74	46.48	35.78	37,9
Дундаж	38,91	43,49	39,67	35,56	39,37
7. Communication 1	72.7	60.75	55.1	61.58	62,5
8. Communication 2	50.68	49.82	34.40	40.02	43,7
Дундаж	61,69	55,29	44,75	50,8	53,1
9. Reading 1	51.75	54.24	34.45	53.13	48,4
10. Reading 2	35.26	34.84	39.26	32.64	35,5
Дундаж	43,5	44,54	36,86	42,89	41,95

Хүснэгт 2-оос харахад:

Хэл зүйн дүрмийн мэдлэг

Дүрмийн 3 хэсэгтэй даалгаврын гүйцэтгэлийн дундаж 37,6%, А хувилбарыг гүйцэтгэсэн сурагчид хамгийн сайн 42,22%, хамгийн бага гүйцэтгэлийг С хувилбарыг гүйцэтгэсэн сурагчид /34,43%/ байна.

Үгийн сан

Үгийн сан ашиглах 3 хэсэгтэй даалгаврын гүйцэтгэл 39,4%, хамгийн сайн гүйцэтгэлийн /43,49%/ хувийг В хувилбарыг гүйцэтгэсэн сурагчид байна. Харин D хувилбарыг гүйцэтгэсэн сурагчид хамгийн бага 35,56%-ийн гүйцэтгэлтэй байна.

Харилцан ярианы даалгавар

Харилцан ярианы 2 хэсэгтэй даалгаврын гүйцэтгэл 53,1%, хамгийн сайн гүйцэтгэсэн нь А хувилбарыг гүйцэтгэсэн сурагчид 61,69%, хамгийн бага гүйцэтгэлийн хувьтай /44,75%/ нь С хувилбарыг гүйцэтгэсэн сурагчид байна.

Уншиж ойлгох чадварын даалгавар

Уншиж, шинжлэн судлах даалгаврын гүйцэтгэл 42%. В хувилбарын сурагчид хамгийн сайн 44,54%, С хувилбарын сурагчид хамгийн бага 36,86%-ийн гүйцэтгэлтэй байна.

Унших чадвар шалгах 2-р хэсгийн 10 даалгаварыг сурагчдын 58,05% нь буруу сонгосон, дүрмийн мэдлэг шалгах 3-р хэсгийн Хэлц үйл үг шалгах 5 даалгавруудыг 67,75% нь буруу сонгосон гүйцэтгэлтэй байна.

Харилцан ярианы 2 хэсгийн даалгаврууд 61,69 %-ийн гүйцэтгэлтэй хийсэн байна. Дүрмийн хэсэг 1,2,3-р хэсгүүдийн нийт 15 даалгаврууд нь хүнд хөнгөний зэрэг дундаж, ялгах чадвар сайтай, сурагчдын гүйцэтгэл сайн дийлэнх сурагчид зөв хариулсан байна. Энэ даалгаврын тавил сайн, сурагчдад танил байна.

График 2.

Хувилбар бүрийн даалгаврын бүтэц ба гүйцэтгэлийн хувь:




График 2-аас харахад:

Даалгавар тус бүрийн гүйцэтгэлийн хувь А хувилбар дээр сайн 46,57%, С хувилбар дээр бага 38,9%. Харилцан ярианы даалгаврын гүйцэтгэлийн хувийн тархалт хувилбар бүр дээр ойролцоо байгаа нь хувилбарууд жигд гүйцэтгэлийн даалгавар болсон.

ЗӨВЛӨМЖЛӨХ НЬ:

Шалгалтын сэдэв тухайн ангийн агуулгын хүрээнд боловсруулагдсан, хэл зүйн дүрэм, үгийн сангийн даалгаврууд нь сурагчдад танил, унших даалгаварын эх нь тусгайлсан мэдлэг чадвар шаардаагүй, сурагчдын танин мэдэхүйг хөгжүүлсэн, сонирхолтой эхийг сонгон авсан. Нийт даалгаврын 33,3% нь уншиж ойлгох чадварыг шалгасан даалгавар байсан.

1. Энэ даалгаврын гүйцэтгэлийн хувь хангалтгүй байгаа нь сурагчдын унших хурд сул, цагийн хуваарилалттай холбоотой байх магадлалтай.

Иймээс ахлах ангийн сурагчдыг унших чадварыг хөгжүүлэхдээ

- Асуултыг эхлээд уншаад юуг мэдэх ёстойгоо ялгаж унших арга барилд сургах
- Гол түлхүүр санааг олох, таамаглуулах чадвар олгох
- Түлхүүр өгүүлбэрт тулгуурлан гол ба туслах санааг тодорхойлох
- Хам сэдвийн хүрээнд үгийн утгыг таамаглуулах
- Үгийн олон утгыг ялган таних арга эзэмшүүлэх
- Адил утгатай үгсийн мэдлэгээ сайжруулах
- Үйл явдлын учир шалтгааныг олох замаар унших ойлгоход чадварт суралцуулах аргыг хичээл сургалтдаа түлхүү хэрэглэхийг зөвлөж байна.

2. Багш нар сурагчдад унших чадвараа илүү ойлгож, задлан шинжлэх, тухайн өгөгдсөн утгаар бус далд санааг өөр үгээр илэрхийлэх чадвар шаардсан дасгал, даалгавар ажиллуулах хэрэгтэй байна.

Багш нар унших дасгалуудыг энгийн танил сэдвүүдээс гадна, JUNIOR TOEFL, FCE зэрэг олон улсын шалгалтын жишгийг дагаж танин мэдэхүйн өргөн хүрээг хамарсан, шинжлэх ухаан, түүх, газарзүй, эдийн засаг, биологи зэрэг сэдвүүдтэй танил болгох шаардлага байна.

Үүнд: Уншиж байгаа өгөгдлөө:

- Ойлгож нарийвчлан үгийн утгыг харьцуулах
- Задлан шинжлэх, хэрэгцээт мэдээллийн талаар нэгтгэн дүгнэх
- Хам сэдвийн хүрээнд үгийн нөөц, үгийн олон утгыг ялган таних
- Хэл зүйн мэдлэгт тулгуурлан үгийн санг баяжуулах
- Хэлц үйл үгийн утгыг хэрэглээ болгох зэргээр сурах чадвараа хөгжүүлж болох юм.

Зөвлөмж бичсэн: Мэргэжилтэн Т. Сараннэмэх

Багш Ч. Нарангэрэл Шинэ Үе сургууль

Багш Б. Энхтуяа Хобби сургууль